

**МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД
БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ
2023 ОНД ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ**

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн 27 дугаар зүйлийн 27.5.4 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, 11.1 дэх хэсэг, Иргэний хуулийн 195-196, 198-202 дахь зүйлийг тус тус үндэслэн:

Нэг талаас Эрүүл мэндийн сайд бөгөөд Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагч С.Чинзориг /цаашид “Захиалагч” гэх/,

Нөгөө талаас Баян-Өлгий аймгийн Засаг даргын орлогч Х.Арман /цаашид “Хэрэгжүүлэгч” гэх/ нар энэхүү гэрээг дор дурдсан нөхцөлөөр байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гэрээний зорилго нь аймгийн Засаг даргад хууль тогтоомжоор олгосон нийтлэг бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай, Эрүүл ахуйн тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан УИХ, Засгийн газар, ЭМЯ-наас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, харьяалах нутаг дэвсгэрийнхээ хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тэгш хүртээмжтэй, чанартай, шуурхай байдлыг хангахад оршино.

1.2. Энэхүү гэрээтэй холбогдох бусад асуудлыг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай (шинэчилсэн найруулга), Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжоор тус тус зохицуулна.

1.3. Гэрээний талууд харьяалах нутаг дэвсгэрийн хүн амд Коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх, тэмцэх чиглэлээр эрүүл мэндийн байгууллагуудын нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээний тогтвортой байдлыг хангах, эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, хүн амд үзүүлэх тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг хангах, хүний нөөцийн хөгжлийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа, үр дүнг санхүүжүүлэх зарчмыг баримтална.

1.4. Гэрээг хоёр эх хувь үйлдэв.

Хоёр. Захиалагчийн эрх, үүрэг

2.1. Захиалагч нь эрүүл мэндийн байгууллагуудаас үзүүлэх тусламж, үйлчилгээний санхүүжилтийг дараах байдлаар санхүүжүүлнэ. Үүнд:

2.1.1. Аймгийн Эрүүл мэндийн газар, Зоонозын өвчин судлалын төвийн үйл ажиллагааны санхүүжилтийг батлагдсан төсвийн дагуу улсын төсвөөс шууд санхүүжүүлнэ.

2.1.2. Аймгийн нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношлогоо эмчилгээний төв, сум, өрхийн эрүүл мэндийн төвөөс үзүүлсэн тусламж, үйлчилгээний санхүүжилтийг тохиолдолд суурилсан гүйцэтгэлээр Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ.

2.1.3. Анхан шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын сангаар дамжуулан санхүүжүүлэх бөгөөд нэг иргэнд ногдох төсвийг гэрээний шалгуур үзүүлэлтийн дагуу санхүүжүүлнэ.

2.2. Хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйцэтгэгчийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулж, гүйцэтгэлээр санхүүжүүлнэ.

2.3. Гэрээний хэрэгжилтийн явцад үүссэн нөхцөл байдлын талаар дүн шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд зохицуулах, дэмжлэг үзүүлэх арга хэмжээ авч, харилцан уялдаатай ажиллана.

2.4. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас сэргийлэх, тэмцэх чиглэлээр эрүүл мэндийн салбараас авах хариу арга хэмжээ, нөөцийн бэлэн байдлыг төлөвлөх, бүрдүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, тогтвортой байдлыг хангах чиглэлд нэгдсэн дэмжлэгт удирдлагаар хангана.

2.5. Коронавируст халдвар (КОВИД-19)-аас цар тахлаас урьдчилан сэргийлэх, халдварын үеийн оношилгоо, эмчилгээ болон бусад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хэвийн тасралтгүй үзүүлэх чиглэлээр мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллана.

2.6. Коронавируст халдвар (КОВИД-19)-аас цар тахлаас сэргийлэх, тэмцэх чиглэлээр эрүүл мэндийн байгууллагуудаас авах хариу арга хэмжээний талаарх мэдээ, мэдээллийг тухай бүрт солилцон тулгамдаж буй асуудлыг харилцан шуурхай шийдвэрлэх зарчмыг баримтлан ажиллана.

2.7. Коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх, тэмцэх чиглэлээр эрүүл мэндийн байгууллагуудаас авах хариу арга хэмжээнд нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжөөр хангахад дэмжлэг үзүүлж ажиллана.

2.8. Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд хэрэгжүүлж байгаа бодлого, арга хэмжээний талаар холбогдох тушаал, шийдвэр, арга зүйн зөвлөмж, мэдээллийг тухай бүрт хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавина.

2.9. Хүн амын дунд зонхилон тохиолдож буй өвчлөл, нас баралтыг бууруулах болон бусад эрүүл мэндийн чиглэлээр зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн удирдлагаар ханган хамтран ажиллана.

2.10. Нийгмийн эрүүл мэнд болон эмнэлгийн тусламж, үйлчилгээний чиглэлээр мэргэжил арга зүйн удирдлагаар ханган хамтран ажиллана.

2.11. Хэрэгжүүлэгчийг эрүүл мэндийн салбараас хэрэгжүүлж буй бодлогын чиглэлээр мэргэжил, арга зүйн удирдлагаар бүрэн хангаж, аймгийн Эрүүл мэндийн газар, эрүүл мэндийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр, үйл ажиллагаа, санаачлагыг хууль эрх зүйн хүрээнд бүрэн дэмжлэг үзүүлж хамтран ажиллана.

Гурав. Хэрэгжүүлэгчийн эрх, үүрэг

3.1. Хэрэгжүүлэгч нь Эрүүл мэндийн тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөө, Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөө зэрэгт тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэн гэрээний үр дүнг Захиалагчийн өмнө хариуцна.

3.2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд “Бүх нийтийг хамруулах”, “Хэнийг ч орхигдуулахгүй байх” зарчмыг баримтлан нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх, тэмцэх чиглэлээр өөрийн харьяа нутаг дэвсгэр дэх эрүүл мэндийн байгууллагын нөөцийн бэлэн байдал, хариу арга хэмжээний чадавхийг бэхжүүлж тогтвортой байдлыг хангаж, “Үйлчлүүлэгч төвтэй” байхаар зохион байгуулж, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагаанд бусад салбар, олон нийтийн байгууллага, иргэдийн оролцоог ханган ажиллана.

3.3. Улс орон даяар зохион байгуулагдаж байгаа урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт өөрийн харьяа нутаг дэвсгэр дэх хүн амыг насны бүлгээр бүрэн хамруулах, энэ чиглэлд ажил олгогчид болон салбар дундын хамтын ажиллагааг ханган манлайлж ажиллана.

3.2.1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас сэргийлэх, тэмцэх үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах чиглэлээр:

3.2.1.1 Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас сэргийлэх, цар тахалтай тэмцэх чиглэлээр салбар дундын оролцоо бүхий багаар халдварын нөхцөл байдал, эрсдэлд тухай бүрт үнэлгээ хийж, хариу арга хэмжээний төлөвлөгөөгөө тодотгон төлөвлөгөөний хэрэгжилт, тайлагналтад хяналт тавьж ажиллана.

3.2.1.2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын шинэ хувилбарын тархалтаас урьдчилан сэргийлэх, тандалтыг эрчимжүүлэх, нийгмийн болон эмнэлгийн тусламж, үйлчилгээг орон нутагт оновчтой, үр дүнтэй зохион байгуулах, нөөцийн бэлэн байдал, шаардлагатай нөөцөөр хангах, шат бүрт хяналт тавих, нэгдсэн удирдлага, зохион байгуулалт, салбар дундын хамтын ажиллагаагаар хангаж ажиллана.

3.2.1.3. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас сэргийлэх, тэмцэх, хариу арга хэмжээг шуурхай авах зорилгоор нөөцийн бэлэн байдлын талаарх мэдээллийн сан бүрдүүлж, тухай бүрд шаардлагатай мэдээ, мэдээллээр баяжуулж, хяналт тавина.

3.2.1.4. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын дэгдэлтийн үед эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хэвийн, тасралтгүй байдлыг хангаж, орхигдуулахгүй ажиллана.

3.2.1.5. Аймгийн нэгдсэн эмнэлэгт полимерадын гинжин урвал (ПГУ) шинжилгээ хийх урвалж, бодисоор тасралтгүй хангана.

3.2.1.6. Нийт хүн ам болон зорилтот бүлэгт чиглэсэн коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахалтай тэмцэх, сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгааг цахим хэлбэрээр тогтмол зохион байгуулна.

3.2.1.7. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахалтай тэмцэх, халдвар хамгааллын дэглэм баримтлах, халдварын үеийн оношилгоо, эмчилгээ зэрэг сэдвээр эрүүл мэндийн ажилтнуудад тасралтгүй байдлаар “сэргээх” сургалт зохион байгуулах, сургалтад цахимаар хамрагдах боломж, нөхцлийг бүрдүүлэн ажиллана.

3.2.2. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр:

3.2.2.1. Улс орон даяар зохион байгуулагдаж байгаа урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт өөрийн харьяа нутаг дэвсгэр дэх хүн амыг насны бүлгээр бүрэн хамруулах, энэ чиглэлд ажил олгогчид болон салбар дундын хамтын ажиллагааг ханган манлайлж ажиллана.

3.2.2.2. Эрүүл мэндийн салбарын хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжих зорилтот хөтөлбөр, арга хэмжээг (“Эрүүл идэвхтэй амьдрал”, “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд”, “Хавдрын эсрэг”, “Харшлаас сэргийлэх”, “Эрүүл чийрэг эр хүн”, “Элэг бүтэн Монгол”, “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх”, “Орчны эрүүл мэнд”) хэрэгжүүлж ажиллана.

3.2.2.3. Сургуулийн өмнөх болон сургуулийн хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, эрүүл мэндийн боловсрол олгох хичээлийн чанар, хүртээмж, амны хөндийн эрүүл мэндийг сайжруулах, осол, гэмтлээс сэргийлэх, “Үдийн хоол” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд салбар дундын оролцоог хангана.

3.2.2.4. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, халдварт өвчний дэгдэлт, цар тахлын үеийн хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангаж ажиллана.

3.2.2.5. Сүрьеэ өвчний илрүүлэлтийн хувийг зорилтот түвшинд (хавсралт) хүргэх, далд хэлбэрийн сүрьеэг илрүүлэх арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тооцно.

3.2.2.6. Бэлгийн замаар дамжих халдвар (БЗДХ)-ыг илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэгт зорилтот бүлгийг хамруулах арга хэмжээг төр, төрийн бус байгууллага, ажил олгогчидтой хамтран зохион байгуулж, халдвартай иргэдийг эмчилгээнд бүрэн хамруулж, эмчилгээний үр дүнг тооцон ажиллана.

3.2.2.7. Сэтгэцийн эрүүл мэнд, ялангуяа хүүхэд, өсвөр үеийнхэнд сэтгэлзүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, архи, тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөл, түүний талаарх мэдлэг олгох, хэрэглээг бууруулах, урьдчилан сэргийлэх болон осол, гэмтлээс сэргийлэх (ахуйн орчны осол гэмтэл, уналт, автотээврийн гэх мэт)-д салбар дундын хамтын ажиллагааг ханган хамтран ажиллана.

3.2.2.8. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах нөхцлийг бүрдүүлэн эрүүл мэндийн байгууллагын гадаад, дотоод орчны тохижилт (тэргэнцэрт зориулсан үүдний хэсэг, хананы бариул, дуугүй хөтөч, тусгайлсан жорлон, дуут дохио гэх мэт)-д үнэлгээ хийж үнэлгээний мөрөөр шаардлагатай арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлж ажиллана.

3.2.2.9. Эрүүл мэндийн боловсрол олгох, мэдээлэл, сургалт, сурталчилгаа, эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлэх үйл ажиллагааг шинэлэг хэлбэрээр зохион байгуулж салбар дундын хамтын ажиллагааг ханган ажиллана.

3.2.2.10. Жил бүр зохион байгуулагддаг оюутны эрүүл мэндийг дэмжих сарын аяны хүрээнд оюутан залуучуудыг эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд бүрэн хамруулахад дэмжлэг үзүүлж ажиллана.

3.2.2.11. Аймгийн авто замын осол ихээр гардаг Хар цэг, түүнтэй ойр байрлах сумын эрүүл мэндийн төвийг ослын үеийн яаралтай түргэн тусламж үзүүлэх нөхцөл боломжоор хангах, хяналт тавих, өмнө байгуулагдсан яаралтай түргэн тусламж үзүүлэх цэгийн үйл ажиллагааны тасралтгүй байдал, нөөц бүрдүүлэлтийг хангахад дэмжлэг үзүүлж ажиллах.

3.2.2.12. Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, мэдээлэл сургалт сурталчилгааг өргөжүүлэх, энэ чиглэлд салбар хоорондын хамтын ажиллагааг ханган ажиллах.

3.2.3. Анхан шатлалын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр:

байгуулах, хүчин чадлыг нэмэгдүүлэх тохиолдолд Захиалагч талтай харилцан зөвшилцсөний үндсэн дээр шийдвэрлэнэ.

3.2.5.2 Эмнэлгийн яаралтай тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулж, тусламж, үйлчилгээг олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлнэ.

3.2.5.3 Нэгдсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээг өргөжүүлэх зорилгоор аймгийн хөгжлийн бодлогод үйл ажиллагаа болон хүний нөөцийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээ, төсөв хөрөнгийг тусган хэрэгжүүлж ажиллана.

3.2.5.4. Эрүүл мэндийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх ялангуяа ядуу, эмзэг бүлгийн иргэд, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, их дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрийн төвийн суралцагчийг бүрэн хамруулах, энэ чиглэлээр орон нутгийн удирдлага, иргэдтэй хамтран ажиллах, эрүүл мэндийн даатгалын талаар мэдээлэл, сурталчилгаа тогтмол хийж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авахтай холбоотойгоор учрах санхүүгийн эрсдэлийг бууруулах нөхцлийг бүрдүүлж ажиллана

3.2.5.5. Эрүүл мэндийн байгууллага бүрт Халдварын сэргийлэлт хяналтын баг, Чанар, аюулгүй байдлын албаны үйл ажиллагааг тогтмолжуулан хяналт тавьж ажиллана.

3.2.5.6. Иргэдийн дунд сайн дурын авлагагүй донорын эгнээг өргөжүүлж аюулгүй цус, цусан бүтээгдэхүүний бэлдмэлийн хангамжийг нэмэгдүүлнэ.

3.2.5.7. Эм, эмнэлгийн хэрэгслийн хэрэгцээг оновчтой тооцон худалдан авах ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, ерөнхий гэрээгээр худалдан авч байгаа эм, эмнэлгийн хэрэгслийг өөр эх сурвалжаас авахгүй байх арга хэмжээ хэрэгжүүлнэ.

3.2.5.8. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх тусламж, үйлчилгээг өргөжүүлэх зорилгоор эрүүл мэнд, боловсрол, нийгмийн халамжийн салбар комиссын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

3.2.6. Эрүүл мэндийн мэдээлэл технологи, цахим шилжилтийн чиглэлээр:

3.2.6.1. Эрүүл мэндийн байгууллагад мэдээлэл, технологийн техник хангамж, сүлжээ, програм хангамжийн дэд бүтцийг өргөжүүлэн хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, тасралтгүй байдлыг хангана.

3.2.6.2. Эрүүл мэндийн яамны Цахим эрүүл мэндийн удирдах хорооны шийдвэрийг үндэслэн, албан ёсны програм хангамж, цахим системийг эрүүл мэндийн байгууллагад ашиглуулах, ашиглалтад хяналт тавьж ажиллана.

3.2.6.3. Эрүүл мэндийн байгууллагуудад цахим мэдээллийн аюулгүй байдлын 4 багц хууль (Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Цахим гарын үсгийн тухай хууль)-ийг чандлан мөрдөж эрүүл мэндийн ажилтнуудад тухайн чиглэлээр тасралтгүй сургалт зохион байгуулна.

3.2.6.4. Эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний мэдээ, мэдээлэл, эмчийн үзлэг, өвчний түүхийг цахим хэлбэрээр цуглуулах, боловсруулах, дамжуулахтай холбоотой цахим соёлыг хэвшүүлнэ.

3.2.6.5. Нотолгоонд тулгуурласан шийдвэр гаргах үйл ажиллагаанд эрүүл мэндийн байгууллага ялангуяа, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын мэдээ, мэдээллийн үнэн зөв, шуурхай байдлыг хангана.

3.2.6.6. Лавлагаа шатлалын болон анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад алсын зайн анагаах ухаан (телемедицин) ашиглах боломжийг бүрдүүлнэ.

3.2.6.7. Нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төвүүдэд ашиглагдаж байгаа эмнэлзүйн “E-Health”, “E-Hospital” програм хангамжийн ашиглалтыг сайжруулж тасралтгүй байдлыг хангаж, мэдээлэл солилцооны нэгдсэн платформ (HIEP) холбоно.

3.2.6.8. Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн байгууллагуудыг өндөр хурдны интернетийн шилэн кабель, эрүүл мэндийн салбарын нэгдсэн VPN сүлжээнд холбоно.

3.2.7. Харьяа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийг дэмжин хөгжүүлэх чиглэлээр:

3.2.7.1. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг хангах, тогтвор суурьшилтай ажиллуулах чиглэлээр санаачлагатай ажиллаж, түрээсийн орон сууц, бусад хэлбэрээр орон сууцтай болгох үйл ажиллагааг дэмжиж ажиллана.

3.2.7.2. Сувилахуйн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулахад шаардлагатай орчин үеийн техник тоног төхөөрөмжөөр хангах, сувилагч, эмнэлгийн тусгай мэргэжилтнүүдийг сургахад дэмжлэг үзүүлэх.

3.2.7.3. Эмнэлгийн мэргэжилтний ажиллан суралцах арга хэмжээг хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж, орон нутгийн эмнэлгийн мэргэжилтэнг лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагад дадлагажуулан сургах, лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагын эмнэлгийн мэргэжилтэнг нэгдсэн эмнэлэг, орон нутгийн анхан шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагад сэлгэн ажиллуулах арга хэмжээг дэмжиж ажиллана.

3.2.7.4. Эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудыг ажлын байрнаас нь хөндийрүүлэхгүйгээр мэргэжил дээшлүүлэх, үндсэн болон төрөлжсөн мэргэшил эзэмших, эрүүл мэндийн удирдах ажилтнуудыг үе шаттайгаар бэлтгэн ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

Бусад үйл ажиллагааны чиглэлээр:

3.2.8. Тусгай зөвшөөрлийн хэрэгцээний үнэлгээ хийх, тусгай зөвшөөрлийн ажлын байрны үзлэг, нөхцөл шаардлагад тавих хяналтын үйл ажиллагаанд төрийн бус байгууллага, мэргэжлийн нийгэмлэгийн оролцоог хангаж, холбогдох бусад байгууллагын үйл ажиллагаатай уялдуулахад нэгдсэн удирдамжаар хангана.

3.2.9. Харьяа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагад зайлшгүй шаардлагатай хөрөнгө оруулалт (тоног төхөөрөмж, барилга, засвар үйлчилгээ), бусад дэмжлэгийг аймгийн Засаг даргын нөөц сан, Орон нутгийн төсвийн хөрөнгө, Орон нутгийн хөгжлийн сангаас шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллана.

3.2.10. Эрүүл мэндийн байгууллагыг цахилгааны тасралтгүй эх үүсвэрээр хангах, цахилгаан эрчим хүчний доголдлоос эмнэлгийн тоног, төхөөрөмж гэмтэх, цахилгааны богино холбоо үүсэх эрсдлээс сэргийлж дотоод хяналтыг тогтмолжуулж, цахилгааны нөөц эх үүсвэрийн бэлэн байдлыг ханган ажиллана.

3.2.11. Эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж байгаа гадаадын зээл, тусламж, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, дэмжлэг тусалцаа үзүүлнэ.

3.2.12. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулахад иргэн, төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлж Нийгмийн эгэх хариуцлагын сайн туршлагыг нэвтрүүлэн ажиллана.

Дөрөв. Гэрээний хэрэгжилт, гэрээний тайлагналт

Аймгийн Эрүүл мэндийн газрын даргатай гэрээ байгуулахад энэхүү гэрээ болон Эрүүл мэндийн газрын саналыг харгалзана.

4.1. Үйл ажиллагааны төсвийн зарлагын хэмнэлт, зардлын бүлэг хооронд шилжүүлэн зарцуулах зохицуулалтыг Төсвийн тухай хуулийн 42, 45, 46 дугаар зүйл, заалтын дагуу Захиалагчид бичгээр хүсэлт гаргаж шийдвэрлүүлнэ.

4.2. Хэрэгжүүлэгч нь Захиалагчийн үйл ажиллагаатай уялдуулан жилийн санхүүжилтийн төсвийн төсөлд оруулах хөрөнгө оруулалтын талаар 2 тал харилцан тохиролцон аливаа нэг давхцал үүсгэхгүй байна.

4.3. Эрүүл мэндийн байгууллагуудын өр, авлагын байдалд хяналт тавин ажиллаж Төсвийн тухай хуулийн 6.2, 6.3, 6.4 болон 16.5.2, 16.5.3, 16.5.5, 57.5-д заасныг мөрдлөг болгон өр, авлага үүсгэсэн орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын Ерөнхий менежертэй хариуцлага тооцож тооцсон талаарх тайлангаа тухай бүрт нь Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ.

4.4. Төсвийн тухай хуулийн 8.9.2 дахь заалтын дагуу орон нутаг дахь эрүүл мэндийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн жилийн тайланг Эрүүл мэндийн газраар нэгтгэн гаргуулж, аудит хийлгэн дараа оны 03 дугаар сарын 05-ны өдрийн дотор Төсвийн ерөнхийлөн захирагчид ирүүлнэ.

4.5. Төсвийн тухай хуулиар Эрүүл мэндийн сайдын багцад батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтын дансаар дамжуулж санхүүжүүлнэ.

4.6. Эрүүл мэндийн сайдын багцаас аймгийн Засаг дарга нарт эрх шилжсэн ажлын явцын мэдээллийг сар бүр Эрүүл мэндийн яаманд дараа сарын 05-ны дотор хүргүүлж байна.

4.7. Хэрэгжүүлэгч нь хагас жилээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлтийг 06 дугаар сарын 15-ны дотор; бүтэн жилээр гэрээний Гуравдугаар зүйлд тусгагдсан үйл ажиллагаа тус бүрийн биелэлт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт, төсвийн гүйцэтгэл, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар дараа оны 01 дүгээр сарын 15-ны дотор Төсвийн ерөнхийлөн захирагчид ирүүлнэ.

Тав. Улсын төсөв болон Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх

5.1. Эрүүл мэндийн газрын санхүүжилтийг энэхүү гэрээний 2 дугаар хавсралтад тусгагдсан төсөв болон Сангийн сайдын баталсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн нэгдсэн дансаар дамжуулан олгоно.

5.2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлээр санхүүжих байгууллагуудын санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын байгууллагатай байгуулсан Тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээний дагуу Эрүүл мэндийн даатгалын сангаар дамжуулах санхүүжүүлнэ.

5.3. Сангийн яамны Төрийн сангийн газар нь санхүүжилтийн төлбөрийг Хэрэгжүүлэгчийн захиран зарцуулах эрх бүхий Төрийн сангийн дансанд сар бүрийн тогтсон хуваарьт өдрүүдэд багтаан шилжүүлэх үүрэг хүлээнэ.

Зургаа. Гэрээний хэрэгжилтийг дүгнэх шалгуур үзүүлэлт, үнэлэх

6.1. Харьяа нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих чиг үүргийг Засгийн газрын өмнө төлөөлөн хэрэгжүүлэх, хөтөлбөр, арга хэмжээ, түүнд

шаардагдах урсгал зардал болон бусад зардал, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт тус бүрээр баталж үнэлнэ.Үүнд:

6.1.1. Эрүүл мэндийн шалгуур үзүүлэлт;

6.1.2. Аймгийн Эрүүл мэндийн газрын 2023 оны төсөв;

6.1.3. 2023 оны хөрөнгө оруулалт.

6.2. Гэрээний хэрэгжилтийг Төсвийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомж, “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгон, хагас жилд үр дүнгийн шалгуур үзүүлэлтээр, бүтэн жилд гэрээний заалт бүрийн хэрэгжилт, гүйцэтгэлийн болон үр дүнгийн шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.

6.3. Захиалагч нь гэрээний үүргийн биелэлтэд үнэлгээ хийж, үнэлгээний дүнг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2024 оны 03 дугаар сарын 01-ний дотор хүргүүлнэ.

Долоо. Гэрээний хугацаа

Энэхүү гэрээний хүчинтэй хугацаа 2023 оны төсвийн жилийн хүрээнд үйлчилнэ.

Найм. Гэрээний үнэ

8.1. Энэхүү гэрээний нийт төсөвт өртөг 4,216,469.1 мянган төгрөг болон гүйцэтгэлээр санхүүжих төсөв байна.

8.2. Хэрэгжүүлэгчийн хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн төсөв, хөгжлийн сан болон бусад эх үүсвэрээс санхүүжилтийг нэмэгдүүлж болно.

Ес. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах

9.1. Гадаад, дотоод орчин өөрчлөгдсөнөөс гэрээг хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд хоёр тал бичгээр мэдэгдэж, харилцан зөвшилцөн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

9.2. Гэрээний өөрчлөлтийг тухай бүрд нь бичгээр үйлдэн Захиалагч, Хэрэгжүүлэгч гарын үсэг зурж, гэрээний эх хувьд хавсаргана. Гэрээний анхны болон өөрчилсөн эхүүдийн хувь тус бүрийг Захиалагч болон Хэрэгжүүлэгч хадгална.

9.3. Гэрээнд тусгагдаагүй үйл ажиллагааг хэрэгжүүлэх асуудлыг талууд харилцан зөвшилцөж, нэмэлт гэрээ байгуулах замаар шийдвэрлэж болно. Ингэхдээ Захиалагчийн төсөвт өртгөөс давсан тохиолдолд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2-т заасан зарчмыг удирдлага болгон төсвийн тодотголоор шийдвэрлүүлэх арга хэмжээ авна.

9.4. Захиалагч гэрээний биелэлтийн үнэлгээний дүнг 2023 оны 04 дүгээр сарын 01-ний дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

Арав. Талуудын хүлээх хариуцлага.

10.1. Гэрээний талууд энэхүү гэрээгээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнг Засгийн газрын өмнө хамтран хүлээнэ.

10.2. Гэрээний шалгуур үзүүлэлт хангасан тохиолдолд Захиалагчаас гүйцэтгэгчийг мөнгөн бус хэлбэрээр урамшуулна.

Арваннэг. Маргааныг шийдвэрлэх

11.1. Төлбөрийн шилжүүлэгтэй холбогдон үүссэн маргааныг Сангийн яаманд хандаж, зохицуулах арга хэмжээг авна.

11.2. Нийлүүлсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ, хугацаа, чанартай холбогдон үүссэн маргааныг гэрээний талууд зөвшилцөж шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

11.3. Зөвшилцөлд эс хүрвэл шүүхийн байгууллагад хандан шийдвэрлүүлнэ.

Арванхоёр. Гэрээ хүчин төгөлдөр болох

Энэхүү гэрээнд талууд гарын үсэг зурж, тамга (тэмдэг) дарж баталгаажуулсанаар хүчин төгөлдөр болно.

Арвангурав. Гэрээний бүрэлдэхүүн хэсэг

13.1. Энэхүү гэрээ нь дараах бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ:

13.1.1. Монгол Улсын Эрүүл мэндийн сайд аймгийн Засаг даргатай 2023 онд хамтран ажиллах гэрээ;

13.1.2. Хавсралт 1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлт;

13.1.3. Хавсралт 2. Аймгийн эрүүл мэндийн байгууллагуудын 2023 оны төсөв;

13.1.4. Хавсралт 3. 2023 онд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт;

13.1.5. Хавсралт 4. Засгийн газрын гишүүнээс аймаг, нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлтийг тайлагнах загвар.

ЗАХИАЛАГЧ:
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД,
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨСВИЙН
ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ



С. ЧИНЗОРИГ

ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:
БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Х. АРМАН

2023 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр
Улаанбаатар хот

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРЫН ҮЗҮҮЛЭЛТ

д/д	Үзүүлэлт	Суурь үзүүлэлт /2022 он/	Хүрэх түвшин /2023 он/
1	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгэнд хамрагдсан 18 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь	25.5	35.5
2	Чихрийн шижин хэв шинж-2 өвчний эрт илрүүлгэнд хамрагдсан 40 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь	40.7	50.7
3	Хөхний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн тоо	14284	14998
4	Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлгэнд хамрагдсан 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь	56.3	61.3
5	Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь	21.0	26.0
6	В вируст гепатитийн эсрэг сэргийлэх тарилгын 24 цагийн хамралтын хувь*	99.7	Суурь үзүүлэлтээс доошгүй
7	Тавт (сахуу, хөхүүл ханиад, татран, В гепатит, хемофилюсинфлюенза) сэргийлэх тарилгын хамралтын хувь /3-р тун/*	94.7	Суурь үзүүлэлтээс доошгүй
8	Улаанбурхан-гахайн хавдар-улаануудын (УГУ) эсрэг сэргийлэх тарилгын хамралтын хувь /2-р тун/*	94.6	Суурь үзүүлэлтээс доошгүй
9	Эхийн эндэгдлийн түвшин (100 000 амьд төрөлт тутамд)	72.1	0.0
10	Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)	14.4	13.9
11	Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)	8.3	7.8
12	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)	20.9	20.2
13	Амьгүй төрөлтийн түвшин (1000 төрөлт тутамд)	6.8	6.3
14	Жирэмсний эхний 3 сард хяналтад орсон эхийн эзлэх хувь	89.1	92.1
15	Өсвөр насны 1000 эмэгтэйд ногдох төрөлтийн түвшин	3.4	2.4
16	Сүрьеэгийн өвчлөлийн түвшин, 10 000 хүн амд	3.1	2.6
17	Вирүст гепатитын өвчлөлийн түвшин, 10 000 хүн амд	1.1	0.6
18	Зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтын түвшин, 10 000 хүн амд	22.1	21.9
19	Хорт хавдраас шалтгаалсан нас баралтын түвшин, 10 000 хүн амд	8.3	7.8
20	Амиа хорлож нас барсан тохиолдлын түвшин, 10 000 хүн амд	0.5	0.3

21	Санамсаргүй хордох, хорт бодист өртсөнөөс шалтгаалсан нас баралтын түвшин, 10 000 хүн амд /Х40-Х49/	0.3	0.1
22	0-5 насны хүүхдийн түлэгдэлтийн түвшин, (10 000 хүүхдэд, Т20-Т32)	24.6	23.6
23	Хүүхдийн зам тээврийн ослын шалтгаант нас баралтын түвшин, (10 000 хүүхдэд, V00-V99)	0.0	0.0
24	Шинээр ажилд авсан сувилагчийн тоо		Гүйцэтгэлээр
25	Хүний нөөцийн хөгжил, нийгмийн баталгааны хөтөлбөрийн тухайн жилийн үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь		Гүйцэтгэлээр
26	Хүний нөөцийг бүрдүүлэх 3-5 жилийн төлөвлөлтийн хэрэгжилтийн хувь		Гүйцэтгэлээр
27	Орон нутгаас байр, орон сууцаар хангасан эмч, мэргэжилтний тоо		Гүйцэтгэлээр
28	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулсан санхүүжилт (чиглэл, төгрөгөөр, хувиар)		Гүйцэтгэлээр
29	Сувилагч мэргэжлээр тайлангийн жилд орон нутгаас зардлыг даан сургасан шинэ суралцагчийн тоо		Гүйцэтгэлээр
30	Хүний нөөцийн хөгжил, нийгмийн хамгааллыг дэмжих, тогтвор суурьшилтай ажиллуулах чиглэлээр Засаг дарга, ИТХ-ын түвшинд гарсан шийдвэрийн хэрэгжилтийн хувь		Гүйцэтгэлээр
31	Тайлангийн жилд орон нутгийн төсвөөс хүний нөөцийн чадавхийг сайжруулах, нийгмийн хамгааллын чиглэлээр зарцуулсан хөрөнгийн хэмжээ /мянган төгрөгөөр/		Гүйцэтгэлээр

Тайлбар:

1. Нас баралт, өвчлөлийн түвшинг 2021 оны дундаж хүн амын тоогоор тооцоолсон.
2. Хөх, умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлгийн хамралтын хувийг урьдчилсан байдлаар тооцоолсон.
3. Дархлаажуулалтын хамралтын хувийг урьдчилсан байдлаар тооцоолсон.

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР, ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН
ТӨВИЙН 2023 ОНЫ ТӨСӨВ**

/мян.төг/

БАЙГУУЛЛАГА	2023 ОНЫ ТӨСӨВ
Баян-Өлгий	4,216,469.1
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,216,469.1
УРСГАЛ ЗАРДАЛ	4,216,469.1
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,373,053.7
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,095,307.9
Үндсэн цалин	672,861.6
Нэмэгдэл	271,428.3
Унаа хоолны Хөнгөлөлт	67,386.0
Урамшуулал	83,632.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	136,913.4
Тэтгэврийн даатгал	93,101.0
Тэтгэмжийн даатгал	10,953.1
ҮОМШ-ний даатгал	8,762.5
Ажилгүйдлийн даатгал	2,190.5
Эрүүл мэндийн даатгал	21,906.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	49,814.8
Гэрэл, цахилгаан	6,650.7
Түлш, халаалт	38,406.6
Цэвэр, бохир ус	4,757.5
Хангамж, бараа материалын зардал	19,454.5
Бичиг хэрэг	2,487.7
Тээвэр, шатахуун	9,626.5
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,886.3
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,214.9
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,239.1
Нормативт зардал	7,663.9
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,770.1
Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,893.8
Эд хогшил, урсгал засварын зардал	9,384.1
Багаж, техник, хэрэгсэл	1,843.6
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,431.6
Урсгал засвар	4,108.9
Томилолт, зочны зардал	7,128.7
Дотоод албан томилолт	7,128.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,921.4
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,978.4
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,249.7
Даатгалын үйлчилгээ	687.3
Тээврийн хэрэгслийн татвар	286.6
Тээврийн хэрэгслийн оношлогоо	86.2
Мэдээллийн технологийн үйлчилгээ	7,331.3
Газрын төлбөр	108.5
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	122.5
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	70.9
Бараа үйлчилгээний бусад зардал	15,465.0
Бараа үйлчилгээний бусад зардал	14,440.6
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,024.4

УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,843,415.4
Бусад урсгал шилжүүлэг	2,843,415.4
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,090,484.2
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	751,727.9
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,203.3
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,216,469.1
Улсын төсвөөс санхүүжих	4,216,469.1
Улсын төсвөөс санхүүжих	4,216,469.1
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	238.0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	2.0
Төсвийн байгууллага	2.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	71.0
Удирдах ажилтан	2.0
Гүйцэтгэх ажилтан	51.0
Үйлчлэх ажилтан	18.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	71.0
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	21.0
Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	28.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	22.0
НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	94.0
Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	94.0
Эрүүл мэндийн газар	3,740,395.9
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,740,395.9
УРСГАЛ ЗАРДАЛ	3,740,395.9
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	897,472.8
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	698,945.9
Үндсэн цалин	421,898.7
Нэмэгдэл	178,913.7
Унаа хоолны Хөнгөлөлт	48,675.0
Урамшуулал	49,458.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,368.3
Тэтгэврийн даатгал	59,410.3
Тэтгэмжийн даатгал	6,989.5
ҮОМШ-ний даатгал	5,591.7
Ажилгүйдлийн даатгал	1,397.8
Эрүүл мэндийн даатгал	13,979.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,678.0
Гэрэл, цахилгаан	5,406.7
Түлш, халаалт	31,513.8
Цэвэр, бохир ус	4,757.5
Хангамж, бараа материалын зардал	13,349.6
Бичиг хэрэг	2,254.1
Тээвэр, шатахуун	6,190.7
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,285.2
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,630.9
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,988.7
Нормативт зардал	2,104.2
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	473.9
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,630.3
Эд хогшил, урсгал засварын зардал	5,977.2
Багаж, техник, хэрэгсэл	934.4
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,824.5
Урсгал засвар	3,218.3
Томилот, зочны зардал	4,091.7
Дотоод албан томилолт	4,091.7

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,492.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,978.4
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,102.7
Даатгалын үйлчилгээ	515.8
Тээврийн хэрэгслийн татвар	90.6
Тээврийн хэрэгслийн оношлогоо	37.7
Мэдээллийн технологийн үйлчилгээ	4,625.6
Газрын төлбөр	44.1
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	98.0
Бараа үйлчилгээний бусад зардал	15,465.0
Бараа үйлчилгээний бусад зардал	14,440.6
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,024.4
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,842,923.1
Бусад урсгал шилжүүлэг	2,842,923.1
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,090,484.2
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	751,727.9
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	711.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,740,395.9
Улсын төсвөөс санхүүжих	3,740,395.9
Улсын төсвөөс санхүүжих	3,740,395.9
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	183.0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.0
Төсвийн байгууллага	1.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	44.0
Удирдах ажилтан	1.0
Гүйцэтгэх ажилтан	32.0
Үйлчлэх ажилтан	11.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	44.0
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	21.0
Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	9.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	14.0
НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	94.0
Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	94.0
Үндсэн үйл ажиллагааны зардал	865,269.3
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	865,269.3
УРСГАЛ ЗАРДАЛ	865,269.3
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	865,269.3
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	698,945.9
Үндсэн цалин	421,898.7
Нэмэгдэл	178,913.7
Унаа хоолны Хөнгөлөлт	48,675.0
Урамшуулал	49,458.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,368.3
Тэтгэврийн даатгал	59,410.3
Тэтгэмжийн даатгал	6,989.5
ҮОМШ-ний даатгал	5,591.7
Ажилгүйдлийн даатгал	1,397.8
Эрүүл мэндийн даатгал	13,979.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	41,678.0
Гэрэл, цахилгаан	5,406.7
Түлш, халаалт	31,513.8
Цэвэр, бохир ус	4,757.5
Хангамж, бараа материалын зардал	13,349.6
Бичиг хэрэг	2,254.1

Тээвэр, шатахуун	6,190.7
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,285.2
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,630.9
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,988.7
Нормативт зардал	2,104.2
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	473.9
Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,630.3
Эд хогшил, урсгал засварын зардал	5,977.2
Багаж, техник, хэрэгсэл	934.4
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,824.5
Урсгал засвар	3,218.3
Томилолт, зочны зардал	4,091.7
Дотоод албан томилолт	4,091.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,514.5
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,102.7
Даатгалын үйлчилгээ	515.8
Тээврийн хэрэгслийн татвар	90.6
Тээврийн хэрэгслийн оношлогоо	37.7
Мэдээллийн технологийн үйлчилгээ	4,625.6
Газрын төлбөр	44.1
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	98.0
Бараа үйлчилгээний бусад зардал	5,239.9
Бараа үйлчилгээний бусад зардал	4,215.5
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,024.4
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	865,269.3
Улсын төсвөөс санхүүжих	865,269.3
Улсын төсвөөс санхүүжих	865,269.3
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	89.0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.0
Төсвийн байгууллага	1.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	44.0
Удирдах ажилтан	1.0
Гүйцэтгэх ажилтан	32.0
Үйлчлэх ажилтан	11.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	44.0
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	21.0
Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	9.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	14.0
Харуул, хамгаалалтын зардал	21,978.4
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	21,978.4
УРСГАЛ ЗАРДАЛ	21,978.4
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	21,978.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,978.4
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	21,978.4
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	21,978.4
Улсын төсвөөс санхүүжих	21,978.4
Улсын төсвөөс санхүүжих	21,978.4
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	2,842,923.1
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,842,923.1
УРСГАЛ ЗАРДАЛ	2,842,923.1
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,842,923.1
Бусад урсгал шилжүүлэг	2,842,923.1
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,090,484.2
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	751,727.9

Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	711.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,842,923.1
Улсын төсвөөс санхүүжих	2,842,923.1
Улсын төсвөөс санхүүжих	2,842,923.1
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	94.0
НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	94.0
Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	94.0
Хөтөлбөр төслийн дотоод урсгал зардал	10,225.1
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,225.1
УРСГАЛ ЗАРДАЛ	10,225.1
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,225.1
Бараа үйлчилгээний бусад зардал	10,225.1
Бараа үйлчилгээний бусад зардал	10,225.1
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	10,225.1
Улсын төсвөөс санхүүжих	10,225.1
Улсын төсвөөс санхүүжих	10,225.1
Зоонозын өвчин судлалын төв	476,073.2
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	476,073.2
УРСГАЛ ЗАРДАЛ	476,073.2
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	475,580.9
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	396,362.0
Үндсэн цалин	250,962.9
Нэмэгдэл	92,514.6
Унаа хоолны Хөнгөлөлт	18,711.0
Урамшуулал	34,173.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,545.1
Тэтгэврийн даатгал	33,690.7
Тэтгэмжийн даатгал	3,963.6
ҮОМШ-ний даатгал	3,170.8
Ажилгүйдлийн даатгал	792.7
Эрүүл мэндийн даатгал	7,927.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,136.8
Гэрэл, цахилгаан	1,244.0
Түлш, халаалт	6,892.8
Хангамж, бараа материалын зардал	6,104.9
Бичиг хэрэг	233.6
Тээвэр, шатахуун	3,435.8
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	601.1
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	584.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,250.4
Нормативт зардал	5,559.7
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,296.2
Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,263.5
Эд хогшил, урсгал засварын зардал	3,406.9
Багаж, техник, хэрэгсэл	909.2
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,607.1
Урсгал засвар	890.6
Томилолт, зочны зардал	3,037.0
Дотоод албан томилолт	3,037.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,428.5
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	147.0
Даатгалын үйлчилгээ	171.5
Тээврийн хэрэгслийн татвар	196.0
Тээврийн хэрэгслийн оношлогоо	48.5
Мэдээллийн технологийн үйлчилгээ	2,705.7
Газрын төлбөр	64.4

Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	24.5
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	70.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	492.3
Бусад урсгал шилжүүлэг	492.3
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	492.3
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	476,073.2
Улсын төсвөөс санхүүжих	476,073.2
Улсын төсвөөс санхүүжих	476,073.2
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	55.0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.0
Төсвийн байгууллага	1.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	27.0
Удирдах ажилтан	1.0
Гүйцэтгэх ажилтан	19.0
Үйлчлэх ажилтан	7.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	27.0
Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	19.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8.0
Үндсэн үйл ажиллагааны зардал	475,580.9
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	475,580.9
УРСГАЛ ЗАРДАЛ	475,580.9
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	475,580.9
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	396,362.0
Үндсэн цалин	250,962.9
Нэмэгдэл	92,514.6
Унаа хоолны Хөнгөлөлт	18,711.0
Урамшуулал	34,173.5
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,545.1
Тэтгэврийн даатгал	33,690.7
Тэтгэмжийн даатгал	3,963.6
ҮОМШ-ний даатгал	3,170.8
Ажилгүйдлийн даатгал	792.7
Эрүүл мэндийн даатгал	7,927.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,136.8
Гэрэл, цахилгаан	1,244.0
Түлш, халаалт	6,892.8
Хангамж, бараа материалын зардал	6,104.9
Бичиг хэрэг	233.6
Тээвэр, шатахуун	3,435.8
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	601.1
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	584.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,250.4
Нормативт зардал	5,559.7
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,296.2
Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,263.5
Эд хогшил, урсгал засварын зардал	3,406.9
Багаж, техник, хэрэгсэл	909.2
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,607.1
Урсгал засвар	890.6
Томилолт, зочны зардал	3,037.0
Дотоод албан томилолт	3,037.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,428.5
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоо	147.0
Даатгалын үйлчилгээ	171.5
Тээврийн хэрэгслийн татвар	196.0
Тээврийн хэрэгслийн оношлогоо	48.5

Мэдээллийн технологийн үйлчилгээ	2,705.7
Газрын төлбөр	64.4
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	24.5
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	70.9
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	475,580.9
Улсын төсвөөс санхүүжих	475,580.9
Улсын төсвөөс санхүүжих	475,580.9
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	55.0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.0
Төсвийн байгууллага	1.0
АЖИЛЛАГСДЫН ТОО	27.0
Удирдах ажилтан	1.0
Гүйцэтгэх ажилтан	19.0
Үйлчлэх ажилтан	7.0
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	27.0
Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	19.0
Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8.0
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	492.3
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	492.3
УРСГАЛ ЗАРДАЛ	492.3
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	492.3
Бусад урсгал шилжүүлэг	492.3
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	492.3
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	492.3
Улсын төсвөөс санхүүжих	492.3
Улсын төсвөөс санхүүжих	492.3

**УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН БАГЦАД 2023 ОНД ХЭРЭГЖИЖ БУЙ
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭ**

Хуулийн дугаар	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Эхлэх	Дуусах	Төсөвт өртөг	2023 онд санхүүжих дүн
XV.1.19	Нэгдсэн эмнэлгийн барилга, 100 ор /Баян-Өлгий, Өлгий сум/	2019	2024	28,656.2	5,765.4
XV.1.30	Эрүүл мэндийн төвийн барилга, 5 ор /Баян-Өлгий, Ногооннуур сум, Ховд баг/	2020	2023	416.7	76.7
XV.1.38	Эрүүл мэндийн төвийн өргөтгөл /Баян-Өлгий, Улаанхус сум/	2020	2023	428.7	84.9
XV.1.78	Эрүүл мэндийн төвийн барилга, 20 ор /Баян-Өлгий, Өлгий сум, Хотгор баг/	2019	2024	1,003.3	50.0
XV.3.5	Эрүүл мэндийн тоног төхөөрөмж /Баян-Өлгий/	2022	2023	300.0	240.0
XV.3.8	Нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмж /Баян-Өлгий, Өлгий сум/	2022	2023	600.0	480.0